2,109.00	Бараа үйлчилгээний бусад зардал	0.00	0.00	48,695,200.00	37,494,302.00
210,901.00	Бараа үйлчилгээний бусад зардал	16,500,000.00	15,914,900.00	29,210,400.00	18,388,279.00
210,902.00	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	15,038,100.00	13,568,200.00	19,484,800.00	19,106,023.00
213.00	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	0.00	0.00	17,240,500.00	17,240,500.00
2,132.00	Бусад урсгал шилжүүлэг	0.00	0.00	17,240,500.00	17,240,500.00
213,205.00	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	8,134,500.00	3,602,450.00	8,043,300.00	8,043,300.00
213,207.00	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	5,384,800.00	5,384,800.00	6,357,200.00	6,357,200.00
213,209.00	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	500,000.00	500,000.00	2,840,000.00	2,840,000.00
22.00	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	0.00	0.00	114,600,800.00	98,598,123.70
2,200.00	Дотоод эх үүсвэрээр	0.00	0.00	114,600,800.00	98,598,123.70
223,001.00	Бусад хөрөнгө	65,370,300.00	36,685,900.00	114,600,800.00	98,598,123.70
23.00	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	0.00	0.00	83,000,000.00	26,647,500.00
230,001.00	Эргэж төлөгдөх зээл	89,500,000.00	490,132,100.00	83,000,000.00	26,647,500.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	0.00	0.00	14,310,494,100.00	2,272,580,237.40
1,310.00	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	0.00	0.00	13,338,607,200.00	1,337,769,021.43
131,007.00	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	869,809,000.00	831,152,958.00	13,338,607,200.00	1,337,769,021.43
1,320.00	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	0.00	0.00	800,345,600.00	820,943,893.97
122,005.00	Орон нутгийн төсвөөс	507,132,300.00	515,788,371.89	715,115,100.00	735,713,584.97
132,007.00	Орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжих	65,370,300.00	65,348,655.00	85,230,500.00	85,230,309.00
1,340.00	НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	0.00	0.00	26,171,000.00	3,025,026.00

Завханмандал сумын Засаг даргын 2021 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

134,002.00	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	0.00	0.00	26,171,000.00	3,025,026.00
120,004.00	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	0.00	0.00	145,370,300.00	110,842,296.00
	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	77,728,800.00	49,983,914.00	77,027,900.00	110,842,296.00
	Урьд оны үлдэгдлээс санхүүжих	36,771,200.00	0.00	68,342,400.00	0.00
4.00	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.00	5,708,834.70	0.00	35,342,403.70
5.00	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0.00	35,342,403.70	0.00	106,431,905.00
6.00	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ	-	-	497.00	491.00
61.00	БАЙГУУЛЛАГЫН ТОО	6.00	6.00	6.00	6.00
610,001.00	Төсвийн байгууллага	6.00	6.00	6.00	6.00
62.00	АЖИЛЛАГСАДЫН ТОО	-	119.00	112.00	109.00
620,001.00	Удирдах ажилтан	-	-	12.00	12.00
620,002.00	Гүйцэтгэх ажилтан	-	-	63.00	63.00
620,003.00	Үйлчлэх ажилтан	-	-	33.00	30.00
620,004.00	Гэрээт ажилтан	-	-	4.00	4.00
63.00	СУРАЛЦАГЧДЫН ТОО (ЖИЛИЙН ДУНДЖААР)	-	-	267.00	267.00
630.00	ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛЬД СУРАЛЦАГЧИД	-	-	163.00	163.00
630,001.00	Төрийн өмчит ЕБС	-	171.00	163.00	163.00
631.00	СУРГУУЛИЙН ӨМНӨХ БОЛОВСРОЛЫН БАЙГУУЛЛАГА	-	-	104.00	104.00
631,001.00	Төрийн өмчит СӨБ байгууллага	-	83.00	104.00	104.00
65.00	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	-	-	112.00	109.00
650,001.00	Төрийн захиргааны албан хаагч (ТЗ)	-	-	7.00	7.00
650,002.00	Төрийн тусгай албан хаагч (ТТ)	-	-	-	-
650,003.00	Ажлын албаны албан хаагч (АА)	-	-	-	-
650,004.00	СӨБ болон бага, дунд боловсролын албан хаагч (ТҮБД)	-	-	58.00	55.00
650,005.00	ШУ-ны салбарын төрийн үйлчилгээний албан хаагч (ТҮШУ)	-	-	-	-
650,006.00	Соёл урлагийн салбарын төрийн үйлчилгээний албан хаагч (ТҮСУ)	-	-	7.00	7.00
650,008.00	Эрүүл мэндийн салбарын төрийн үйлчилгээний албан хаагч (ТҮЭМ)	-	-	24.00	24.00
650,009.00	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	-	-	8.00	8.00
650,010.00	Гэрээт ажилтан	-	-	1.00	1.00
650,011.00	Улс төрийн албан хаагч (УТ)	-	-	7.00	7.00

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Гүйцэтгэл
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	9,255,293.00	204,923,295.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	9,255,293.00	203,108,295.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	9,255,213.00	126,153,607.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	0.00	8,988,900.00
210102	Нэмэгдэл	0.00	3,633,900.00
210104	Урамшуулал	0.00	5,355,000.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	0.00	663,000.00

Завханмандал сумын Засаг даргын 2021 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

210201	Тэтгэврийн даатгал	0.00	663,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	1,434,600.00	6,066,800.00
210401	Бичиг хэрэг	0.00	145,900.00
210402	Тээвэр, шатахуун	144,400.00	4,759,800.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	0.00	180,000.00
210404	Ном, хэвлэл	115,700.00	0.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,174,500.00	981,100.00
2105	Нормативт зардал	2,392,440.00	26,283,600.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	0.00	21,016,200.00
210502	Хоол, хүнс	2,392,440.00	5,267,400.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	350,000.00	0.00
210604	Урсгал засвар	350,000.00	0.00
2107	Томилолт, зочны зардал	0.00	825,000.00
210702	Дотоод албан томилолт	0.00	825,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	4,629,348.00	3,491,833.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	4,380,348.00	3,491,833.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	249,000.00	0.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	448,825.00	79,834,474.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	448,825.00	76,232,354.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	0.00	3,602,120.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	80.00	52,580,188.00
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	80.00	0.00
213101	Засгийн газрын дотоод шилжүүлэг	80.00	0.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	0.00	52,580,188.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	0.00	13,780,188.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	0.00	38,800,000.00
2133	Олгосон санхүүжилт, шилжүүлэг	0.00	24,374,500.00
213403	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, төвлөрүүлэх шилжүүлэг	0.00	24,374,500.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	0.00	1,815,000.00
2200	Дотоод эх үүсвэрээр	0.00	1,815,000.00
225001	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	0.00	1,815,000.00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	0.00	204,923,375.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	0.00	204,923,375.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	0.00	7,590,000.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	0.00	1,200,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	0.00	196,133,375.00
IV	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)	0.00	80.00
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.00	0.00
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0.00	80.00

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Завханмандал сумын Засаг даргын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч байгууллагад дотоод хяналттай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Завхан аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Г.Чулуунбаатар гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Б.Дагвасүрэн, дарга, тэргүүлэх аудитор Д.Бат-Ундраа нар тус тус хэрэгжүүлсэн.

Завханмандал сумын Засаг даргын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Завхан аймаг дахь Төрийн Аудитын газарт 2022 оны 03 дугаар сарын 14-ний өдрийн 01/37 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Байгууллагын зорилго, зорилт, үйл ажиллагааны чиглэл:

“Тогтвортой хөгжлийн үзэл баримтлалд тулгуурласан төр засгийн бодлого үйл ажиллагаатай нийцсэн, орон нутгийн онцлог нөөц чадавхыг бүрэн дайчилсан, судалгаанд суурилсан эдийн засаг нийгмийн бодлогыг хэрэгжүүлж, хүмүүнлэг ардчилсан нийгмийн шаардлагад нийцсэн, төрийн үйлчилгээг хүн амд ил тод шуурхай хүртээмжтэй хүргэх” гэсэн зорилгын хүрээнд дараах зорилтыг дэвшүүлэн ажилласан байна. Үүнд:

- Үндэсний нэгдмэл бахархлыг сэргээж, эх хэл, түүх, өв соёлоо дээдэлсэн эх оронч үзэл, эв нэгдлийг эрхэмлэсэн Монгол хүнийг хөгжүүлж, нийгмийг соён гэгээрүүлэх;
- Нийгмийн суурь үйлчилгээг тэгш, хүртээмжтэй, чанартай хүргэх тогтолцоог бэхжүүлж, эрдэм мэдлэгтэй, эрүүл чийрэг, нийгмийн идэвхитэй, хүнлэг, ёс суртахуунтай, дэлхийд үнэлэгдэх Монгол хүнийг төлөвшүүлж, гэр бүлд ээлтэй хүний хөгжлийн цогц бодлого хэрэгжүүлэх;
- Боловсролын чанарыг сайжруулж “Чадварлаг багш” хөтөлбөр боловсруулах;
- Соёл, спортын үйлчилгээг жигд үзүүлэх;
- Эрүүл мэндийн чанар, хүртээмжтэй, үр дүнтэй тогтолцоог бүрдүүлж “Чадварлаг эмч” хөтөлбөр боловсруулах;
- Гэр бүлд ээлтэй бодлого хэрэгжүүлж, хүний хөгжлийг дэмжих;
- Хүн амын хөдөлмөр эрхлэлтийг дэмжиж, өрхийн орлогыг нэмэгдүүлэн, хүн амыг орон сууцаар хангах тогтолцоог бий болгож, дундаж давхаргын хүрээг тэлж, амьдралын чанарыг дээшлүүлэх;
- Эдийн засгийн тогтвортой өсөлт иргэн бүрдээ хүрсэн, дундаж давхарга нэмэгдэж, ядуурал буурсан, эдийн засгийн хөгжлийн бодлогын суурийг бүрдүүлж, нефть, шатахууны дотоодын хэрэгцээг өөрсдөө хангадаг экспорт эрчимжсэн, хөрөнгө оруулалт, хуримтлалын чадавхаа дээшлүүлэх;
- Хүрээлэн байгаа орчны бохирдол, доройтлыг бууруулах, байгалийн баялгийг зүй зохистой ашиглах, нөхөн сэргээх, байгальд ээлтэй дэвшилтэт ногоон технологи нэвтрүүлж уур амьсгалын өөрчлөлтийг сааруулах, дасан зохицох бодлогыг хэрэгжүүлж хүн амын эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхийг хангах;
- Нийгмийн амар тайван байдлыг хангах, хууль сахиулах салбарыг хөгжүүлэх;

- Цэргийн алба хаах насны иргэдэд эх оронч үзэл, хүмүүжлийг төлөвшүүлэх, иргэн цэргийн харилцааг бэхжүүлэн, иргэдэд эх орноо хамгаалахад оролцох, цэргийн бэлтгэл эзэмшүүлэх замаар улс орны батлан хамгаалах, нөөц чадавхыг нэмэгдүүлэх;
- Эрсдэлгүй, өндөр ашиг шим бүхий хөдөө аж ахуйг хөгжүүлэх;
- Дэд бүтцийг сайжруулах;

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна гэж үзлээ.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Сумын засаг даргын дэргэд дотоод хяналтын нэгжийг байгуулсан байна. Энэхүү хяналтын нэгж нь ТШЗ-ийн үйл ажиллагаанд хяналтыг хангалттай хэмжээнд хэрэгжүүлээгүй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудиторос шууд тусалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Завханмандал сумын Засаг даргын 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр хөрөнгийг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшнийг 1.5 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны нийт хөрөнгийн дүнгийн 4,305.39 сая төгрөгийн 1.5 хувь буюу 64.58 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 75 хувь буюу 48.43 сая төгрөгөөр тус тус тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Мөнгөн хөрөнгө

Мөнгөн хөрөнгийн дансны үлдэгдэл 138.29 сая төгрөг болж өмнөх оноос 87.54 сая төгрөгөөр өссөн байна. Мөнгөн хөрөнгийн 69.30 сая төгрөг нь Сум хөгжүүлэх сангийн, 36.80 сая

төгрөг нь Орон нутгийн хөгжлийн сангийн, 0.32 сая төгрөг нь Эрүүл мэндийн төвийн, 31.87 сая төгрөг нь Орон нутгийн ерөнхий орлогын дансны үлдэгдэл байна.

Авлага

Авлагын дансны үлдэгдэл 165.14 сая төгрөг болж өмнөх оноос 35.90 сая төгрөгөөр буурсан нь хувь хүмүүсээс авах авлагын барагдуулалттай холбоотой байна.

/төгрөгөөр/

Байгууллагын нэр	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
Засаг даргын тамгын газар	490,720.00	0.00
Иргэдийн Төлөөлөгчдийн хурал	0.00	121,800.00
Эрүүл мэндийн төв	0.00	18,246,500.00
Соёлын төв	0.00	59,229.00
Сум хөгжүүлэх сан	199,323,910.00	146,593,226.00
Ерөнхий боловсролын сургууль	91,512.00	71,323.00
Хүүхдийн цэцэрлэг	1,140,682.50	57,030.33
Дүн	201,046,824.50	165,149,108.33

Бараа материал

Бараа материалын дансны үлдэгдэл 303.96 сая төгрөг болж өмнөх оноос 70.36 сая төгрөгөөр өссөн нь Эрүүл мэндийн төвд "Ковид-19" цар тахалтай тэмцэх, урьдчилан сэргийлэх ажлын хүрээнд эм, эмнэлгийн хэрэгслийн нөөц бүрдүүлсэнтэй холбоотой байна.

Үндсэн хөрөнгө

Үндсэн хөрөнгийн дансны үлдэгдэл 3,697.98 сая төгрөг болж өмнөх оноос 412.48 сая төгрөгөөр өссөн нь Засаг даргын нөөц хөрөнгөөс тавилга эд хогшил, сумын ОНХС-аас тоног төхөөрөмж, тавилга эд хогшил, Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар худаг, БШУЯ-ны хөрөнгө оруулалтаар тоног төхөөрөмж, ном, тавилга эд хогшил, төсвийн хөрөнгөөр тоног төхөөрөмж, ЭМЯ-ны хөрөнгө оруулалтаар тоног төхөөрөмж, тавилга эд хогшил, НҮБ-ын хөрөнгө оруулалтаар эцэг эхийн клуб тохижилтын тоног төхөөрөмж, Багш хөгжлийн төвийн тоног төхөөрөмж худалдан авсан зэрэгтэй холбоотой байна.

Богино хугацаат өр төлбөр

Өглөгийн дансны үлдэгдэл 0.00 сая төгрөг болж өмнөх оноос 1.61 сая төгрөгөөр буурсан нь ажилчидтай холбоотой өглөгийг барагдуулсантай холбоотой байна.

/төгрөгөөр/

Байгууллагын нэр	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
Засаг даргын тамгын газар	1,280,447.00	0.00
Иргэдийн Төлөөлөгчдийн хурал	186,373.00	0.00
Соёлын төв	151,116.00	0.00
Дүн	1,617,936.00	0.00

Цэвэр хөрөнгө

Цэвэр хөрөнгийн дүн 4,305.39 сая төгрөг болж өмнөх оноос 536.10 сая төгрөгөөр өссөн нь тайлант хугацааны үр дүнтэй холбоотой байна.

Төсвийн шууд захирагчийн илрүүлэлт:

- Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолын 1.6 дахь заалтыг зөрчиж "Төлөөлөгчийн нэг өдөр" арга хэмжээ зохион байгуулан, бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамжийн зардлаас 1.45 сая төгрөгийг няравын хувийн дансаар дамжуулан зарцуулсан;
- Няравын дансаар мөнгө дамжуулан зарцуулсан;
- Зардлын эдийн засгийн ангилал гүйлгэн зарцуулсан;

- Бараа үйлчилгээний бусад зардлаас томилолт олгож, зардлын эдийн засгийн ангилал гүйлгэн зарцуулсан;
- Засаг даргын нөөц хөрөнгийг зориулалт бус, үрэлгэн зарцуулсан;
- “Ковид 19” цар тахлын зардлаас ажилчдад биеийн тамирын хувцас бэлтгэсэн зэрэг нийт 28.98 сая төгрөгийн зөрчилд зөвлөмж хүргүүлэхээр шийдвэрлэсэн.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус төвлөрүүлэн захирагчийн 2021 оны төсвийн зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр болон зарлагыг анх батлахдаа 2,310.49 сая төгрөгөөр тооцон төлөвлөж баталсан байна.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн төвлөрүүлэн захирагчийн хэрэгжүүлэх хөтөлбөрт зориулан 2,310.49 сая төгрөгийн төсөв батлагдсанаас 2,112.89 сая төгрөгийг урсгал зардалд, 114.60 сая төгрөгийг хөрөнгийн зардалд, 83.00 сая төгрөгийг эргэн төлөгдөх зээлд зарцуулахаар баталжээ.

Нийт зардлын 1,338.60 сая төгрөгийг улсын төсвөөс, 715.11 сая төгрөгийг орон нутгийн төсвөөс, 26.17 сая төгрөгийг эрүүл мэндийн даатгалын сангаас, 85.23 сая төгрөгийг орон нутгийн хөгжлийн сангаас, 77.02 сая төгрөгийг үндсэн үйл ажиллагааны орлогоос, 68.36 сая төгрөгийг урд оны үлдэгдлээс санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 1,337.76 сая төгрөг, орон нутгийн төсвөөс 735.71 сая төгрөг, эрүүл мэндийн даатгалын сангаас 3.02 сая төгрөг, орон нутгийн хөгжлийн сангаас 85.23 сая төгрөг, үндсэн үйл ажиллагааны орлогоос 92.78 сая төгрөг, нийт 2,254.50 сая төгрөгийн санхүүжилтийг олгосон нь 55.99 сая төгрөгийн санхүүжилт дутуу байна.

Үндсэн үйл ажиллагааны орлого буюу сум хөгжүүлэх сангийн зээлийн эргэн төлөлтийн орлогоор 92.76 сая төгрөг бүрдүүлж, батлагдсан төсвөөс 15.73 сая төгрөгөөр давсан нь зээлийн эргэн төлөлт хугацаандаа төлөгдсөнтэй холбоотой байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 2,198.84 сая төгрөг буюу 95.16 хувьтай байгаа нь төсөвт санхүүжилт дутуу олгогдсон, эргэн төлөгдөх зээлийг төлөвлөсөн хэмжээгээр олгоогүй, ОНХС-ийн төлөвлөсөн ажлыг бүрэн хэрэгжүүлээгүй зэрэгтэй холбоотой байна.

Урсгал санхүүжилтийн зарцуулаагүй үлдэгдэл 0.36 сая төгрөгийг сумын төсөвт, 0.16 сая төгрөгийг аймгийн төсөвт, 0.00 сая төгрөгийг улсын төсөвт тус тус төвлөрүүлсэн байна.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Засаг даргын нөөц хөрөнгөөс 1.20 сая төгрөгийн, төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламжаас 7.59 сая төгрөгийн, дээд шатны төсвийн захирагчаас 196.13 сая төгрөгийн, үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлогоос 0.00 сая төгрөгийн, нийт 204.92 сая төгрөгийн орлогыг бүрдүүлжээ.

Үүнээс урсгал зардалд 204.92 сая төгрөгийг бүрэн зарцуулсан байна.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн тайланд онцлон үзэх эрсдэлтэй асуудал тусгагдаагүй байна.

3.8 Аудитын гол асуудал

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

Аудитын хүрээнд төсвийн төвлөрүүлэн захирагчийн худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, түүний биелэлттэй танилцахад эрсдэлтэй асуудал ажиглагдаагүй болно.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд оруулбал зохих 155 мэдээллээс, 142 мэдээллийг шилэн дансны цахим хуудсанд хугацаанд нь байршуулж, 10 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн, 2 мэдээллийг огт мэдээлээгүй, 1 мэдээллийн хугацаа болоогүй байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн байна гэж дүгнэлээ.

3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Завханмандал сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн үйл ажиллагаанд мөрдөж буй хууль тогтоомжийн хүрээнд бусад мэдээлэлтэй танилцахад эрсдэлтэй асуудал ажиглагдаагүй болно.

3.10 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн үйл ажиллагаанд завсрын аудит хийгдээгүй бөгөөд өмнөх санхүүгийн тайлангийн аудитаар алдаа, зөрчил илрээгүй байна.

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар анхаарах эрсдэлтэй асуудал байхгүй байна.

4. Аудитын илрүүлэлт

Төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн аудитаар нийт 28.98 сая төгрөгийн зөрчил илэрч зөвлөмж хүргүүлэхээр шийдвэрлэсэн.

4.1 Залруулсан алдаа

Санхүүгийн тайлангийн аудитаар залруулсан алдаа илрээгүй байна.

4.2 Төлбөрийн акт

Санхүүгийн тайлангийн аудитаар төлбөрийн акт тогтоох алдаа зөрчил илрээгүй байна.

4.3 Албан шаардлага

Санхүүгийн тайлангийн аудитаар албан шаардлага өгөх алдаа зөрчил илрээгүй байна.

4.4 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав.
Үүнд:

1. Хяналттай холбоотой асуудал

Илрүүлэлт: Төсвийн шууд захирагчдын аудитаар илэрсэн алдаа зөрчилд дүн шинжилгээ хийхэд, шууд захирагчдын төрийн сангаар хийгдэж буй ажил гүйлгээнд хяналт тавиагүй, дотоод хяналт хэрэгжүүлээгүйтэй холбоотой зөрчил байна. Тухайлбал: Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолын 1.6 дахь заалтыг зөрчиж "Төлөөлөгчийн нэг өдөр" арга хэмжээ зохион байгуулан, бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамжийн зардлаас няравын хувийн дансаар дамжуулан зарцуулсан, няравын дансаар мөнгө дамжуулан зарцуулсан, зардлын эдийн засгийн ангилал гүйлгэн зарцуулсан, бараа үйлчилгээний бусад зардлаас томилолт олгож, зардлын эдийн засгийн ангилал гүйлгэн зарцуулсан, засаг даргын нөөц хөрөнгийг зориулалт бус, үрэлгэн зарцуулсан, "Ковид 19" цар тахлын зардлаас ажилчдад биеийн тамирын хувцас бэлтгэсэн зэрэг зөрчлүүд байна.

Энэ нь Засгийн Газрын 2011 оны 311 дүгээр тогтоолоор батлагдсан "аж ахуй нэгжийн үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах нийтлэг журам"-ын 3 дугаар зүйлийн 3.7.6. /хяналт шалгалтын явцад илэрсэн зөрчлийг арилгах, урьдчилан сэргийлэх талаар мэргэжил арга зүйн зөвлөгөө өгөх/, Засгийн Газрын 2015 оны 24 дүгээр тогтоолоор батлагдсан "Төрийн сангийн үйл ажиллагааны журам"-ын 7 дугаар зүйлийн 7.13.7 /энэхүү журмын 7.8-д заасан анхан шатны баримт дутуу, иж бүрдэл болоогүй тохиолдолд/, 8 дугаар зүйлийн 8.4 /Төрийн сан төсвийн байгууллагаас ирүүлсэн төлбөрийн болон бэлэн мөнгөний хүсэлтийг холбогдох баримт, цахим хэлбэрээр шивсэн гүйлгээ, батлагдсан төсвийн зарцуулалтын эрх, хөтөлбөр, зориулалт арга хэмжээ, эдийн засгийн ангиллын дагуу бүлгийн дүнд багтаан төлбөрийг гүйцэтгэнэ. Төлбөрийн хүсэлт, холбогдох баримт нь шаардлага хангаагүй, батлагдсан төсөв, хөтөлбөр, зориулалт арга хэмжээ, эдийн засгийн ангилал, бүлгийн дүн нь төлбөр гүйцэтгэх хэмжээний эх үүсвэргүй тохиолдолд гүйлгээг буцаана/ гэсэн заалтууд, ангилал, нийцсэн бөгөөд зохистой байх гэсэн батламж мэдээдлүүдтэй нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Төсөв захирагчдын үйл ажиллагаанд тавих хяналтыг сайжруулж, арга зүйгээр хангаж ажиллах;

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Төрийн Аудитын байгууллагад 2022 оны 09 дүгээр сарын 25-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Санхүүгийн тайлангийн аудитын асуудал											

1	Иргэдийн төлөөлөгчдийн хурал	4	3.76	-	0.00	-	0.00	-	0.00	4	3.76
2	Засаг даргын тамгын газар	17	318.56	6	83.64	1	1.13	6	22.61	4	211.18
3	Ерөнхий боловсролын сургууль	7	25.02	1	13.78	1	0.18	-	0.00	5	11.06
4	Хүүхдийн цэцэрлэг	6	7.97	2	1.79	1	0.13	-	0.00	3	6.05
5	Эрүүл мэндийн төв	10	645.80	3	20.29	2	17.92	-	0.00	5	607.59
6	Соёлын төв	9	75.62	5	18.82	1	0.25	-	0.00	3	56.55
7	Орон нутгийн хөгжлийн сан	3	26.96	-	0.00	-	0.00	-	0.00	3	26.96
8	Төвлөрүүлэн захирагч	6	28.98	-	0.00	-	0.00	-	0.00	6	28.98
Дүн		62	1,132.67	17	138.32	6	19.61	6	22.61	33	952.13

БОЛОВСРУУЛСАН:

АУДИТОР

ХЯНАСАН:

Г.ЧУЛУУНБААТАР

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Д.БАТ-УНДРАА

АУДИТЫН МЕНЕЖЕР

Б.ДАГВАСҮРЭН

2022.03.25